



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/487

Хэрлэн сум

Усны түвшин хэмжигч автомат төхөөрөмж суурилуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Ус, цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үер усны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх зорилгоор Хэрлэн, Онон голын гүүрэн байгууламжид усны түвшин хэмжигч автомат төхөөрөмж суурилуулах ажлын зардалд 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Автомат төхөөрөмжийг холбогдох заавар зөвлөмжийн дагуу суурилуулах, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
 08 дугаар сарын 26-ний өдрийн
 А/487 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Зардлын нэр	Хэмжих нэгж/тоо хэмжээ	Нийт дүн
Шатахуун	450 км * 90 л	300,000
Томилолт	4 хүн * 4 хоног 1 хүн * 2 хоног	1,620,000
Шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж		880,000
Бүгд		2,800,000